

## **ТӨРӨӨС ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО /2017-2027/**

### **Нэг. Ерөнхий мэдээлэл**

Монгол улсын нутаг дэвсгэрт 2017 оны III улирлын байдлаар газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3 эрлийн гэрээ хэрэгжиж байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу 22 талбайд газрын тосны хайгуул, 3 талбайд олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Шинээр 3 талбайд БХГ байгуулах шатанд, 2 талбайд сонгон шалгаруулалт зарлаж, 1 талбай нээлттэй байна.

Нийт нутаг дэвсгэрийн 25% буюу 391 мянган км<sup>2</sup> талбайд 1:200000 масштабын хүндийн хүчнийн судалгаа, 33494 тууш.км хоёр хэмжээст, 6274 кв.км талбайд гурван хэмжээст чичирхийллийн судалгаа, 210 физик цэгт пассив сейсм, 21990 км агаарын 5 сувагт градиометрийн судалгаа хийгдэж, 1534 цооногийн өрөмдлөгийн ажлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр гүйцэтгэсэн.

Газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнд Монгол улс олборлогч орон болж, олборлолтод шилжсэн 3 талбайн хувьд 332,64 сая тн газрын тосны баталгаат нөөц, 43,258 сая тн ашиглалтын баталгаат нөөцийг тогтоож, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн. 1996-2016 онуудад 41.6 сая баррель (5.6 сая тонн) газрын тос олборлож, экспортлон улсын төсөвт 1.18 их наяд төгрөг, 2017 онд 6.04 сая баррель (821.9 мян.тонн) газрын тос олборлож, экспортлон улсын төсөвт 162.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

Монгол улсын их хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны уйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70-д “Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна” гэж заасан. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 92-р тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит компани байгуулах шийдвэр гарч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017.04.04-ний 108-р тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК байгуулагдсан.

2015 онд хийсэн урьдчилсан ТЭЗҮ-ээр Сайншандад 1.5 сая тн-ын хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэр барихаар шийдвэрлэж, нарийвчилсан ТЭЗҮ-ийг Энэтхэгийн ЗГ-аас өгөх урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр Энэтхэгийн төрийн өмчит компани гүйцэтгэж байна. Монгол Улсын олборлолтын хэмжээ 2016 онд 1.1 сая тн, 2017 онд 960 мян тн, цаашдаа 1 сая тн орчим байх тул газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой хангахын тулд газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлж нөөц өсгөх, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Мөн “газрын тосны салбарт 2017 он хүртэл төрөөс баримтлах бодлого”-ын хугацаа дууссан, хөрөнгө оруулагчид монгол улсын газрын тосны салбарын бодлогыг хүлээж, хөрөнгө оруулалт зогсонги байдалд ороод байгаа тул яаралтай газрын тосны салбарын бодлогыг батлуулах шаардлага тулгараад байна.

## **Хоёр. Бодлогын зорилго, зарчим, зорилт**

### **2.1. Бодлогын зорилго**

Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлого /цаашид “бодлого” гэх/-ын гол зорилго нь Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх замаар газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгоход оршино.

### **2.2. Бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

Бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.2.1 Нийгэм эдийн засгийн хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах;

2.2.2. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байх;

2.2.3. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;

2.2.4. Бодлогын хэрэгжилт ил тод, нээлттэй, олон улсын жишигт нийцсэн байх

### **2.3. Бодлогын зорилтууд:**

2.3.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх;

2.3.2. Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

2.3.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;

2.3.4. Газрын тосны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, ажлын байрыг нэмэгдүүлэх;

2.3.5. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийг дэмжих;

2.3.6. Газрын тосны салбарын мэдээлэл, судалгаа, шинжилгээний төв байгуулах;

2.3.7. Газрын тосны компани байгуулж, салбарыг хөгжүүлэх;

## **2.4.Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:**

### **2.4.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх чиглэлээр:**

2.4.1.1. газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүтээгдэхүүн хуваах, татвар-роялти, бусад гэрээний зарчмаар явуулах;

2.4.1.2. газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд төр, орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;

2.4.1.3. газрын тостой холбогдсон үйл ажиллагааны татварын зохицуулалтыг боловсронгуй болгох;

2.4.1.4. газрын тостой холбогдсон үйл ажиллагааны стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, шинээр боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

2.4.1.5. улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажил гүйцэтгэж, хэтийн төлөвийг тодорхойлох;

2.4.1.6. газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтын урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх,

2.4.1.7. газрын тосны ордын дэд бүтцийг хөгжүүлэх, тээвэрлэлтийн менежментийг боловсронгуй болгох,

2.4.1.8 Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлосон газрын тосыг дотоодын боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд нийлүүлэх;

### **2.4.2. Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр**

2.4.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлож буй газрын тосыг боловсруулах төрийн өмчийн оролцоотой үйлдвэр байгуулах;

2.4.2.2. олон улсын патенттай технологи ашиглан чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;

2.4.2.3. нүүрс боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрлэлийг газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн бодлоготой уялдуулах;

2.4.2.4. уламжлалт бус газрын тосны эх үүсвэрээс /нүүрсний давхаргын метан, занар, байгалийн битум, тослог элс г.м/ шингэн болон хийн түлш боловсруулах судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэлийг дэмжих;

### **2.4.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр**

2.4.3.1. чанарын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах,

2.4.3.2. газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэх, шатахууны үнийн хэлбэлзлийг зохицуулах зорилгоор Эрсдлийн сан бий болгох,

2.4.3.3. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, техник ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох, шинээр боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

2.4.3.4. газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч орнуудтай нийлүүлэлтийг тогтвортой хангах талаар Засгийн газрын түвшинд тохиролцох, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.4.3.5. дэвшилтэт техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх замаар газрын тосны бүтээгдэхүүн түгээх байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах,

2.4.3.6. газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх итгэмжлэгдсэн лаборатори байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог бий болгох;

2.4.3.7. агаарын бохирдлыг бууруулах экологийн цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор хийн салбарыг хөгжүүлэх,

#### **2.4.4. Газрын тосны салбарын мэргэжлийн боловсон хүчин, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр**

2.4.4.1. Газрын тосны салбарт эрэлт, шаардлагатай байгаа болон цаашид шаардагдах ажил, мэргэжил, боловсон хүчний судалгаа хийн, боловсон хүчнийг бэлтгэх төлөвлөгөө боловсруулж батлах.

2.4.4.2. Судалгаа, төлөвлөгөөний дагуу газрын тосны салбарын мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтан, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх

2.4.4.3. Сургалтын урамшууллын хөрөнгийг газрын тосны салбарын боловсон хүчин, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх болон судалгаа, шинжилгээний ажилд зарцуулах,

2.4.4.4. Сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцсан төгсөгчдийг ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

2.4.4.5 Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд үндэсний мэргэжлийн болон мэргэжилтэй боловсон хүчний оролцоо, ажил эрхлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх

#### **2.4.5. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр**

2.4.5.1. байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологи, ногоон хөгжлийг дэмжих, олон улсын тэргүүн туршлага, стандартыг нэвтрүүлэх;

2.4.5.2. газрын тосны ордын ашиглалт, үйлдвэрлэлтэй холбогдсон дэд бүтцийг барьж байгуулах, ажлын байр нэмэгдүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.

2.4.5.3. газрын тосны нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг газрын тосны үйл ажиллагаа явагдаж буй бүс нутагт нь хуваарилах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх;

#### **2.4.6. Газрын тосны салбарын мэдээлэл, судалгаа, шинжилгээний төв байгуулах чиглэлээр**

2.4.6.1. газрын тосны хайгуулын үр дүнгийн анхдагч материал боловсруулах, чулуун болон тосны дээжинд шинжилгээ хийх, салбарын хэмжээний нэгдсэн тайлан боловсруулах, эрдэм шинжилгээний болоод сэдэвчилсэн судалгааг тогтмол хийх судалгаа, шинжилгээний төв байгуулах,

2.4.6.2. олон улсын стандартын шаардлагад нийцсэн газрын тосны салбарын иж бүрэн мэдээллийн цахим сан байгуулах;

#### **2.4.7. Газрын тосны компани байгуулж, салбарыг хөгжүүлэх чиглэлээр:**

2.4.7.1 Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулж, хөгжүүлэх;

2.4.7.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газарт ногдох түүхий тосны борлуулалтын орлогоос санхүүжүүлэх:

#### **Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

3.1. Бодлогыг 2018-2027 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

нэгдүгээр үе шат: 2018-2021 он;

хоёрдугаар үе шат: 2022-2027 он.

#### **Дөрөв. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт**

4.1. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож 2017 оны тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон авч үзнэ:

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах  
нийтлэг журмын 5 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд*
				2017	2022	2027		
1	2.4.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх	Газрын тосны хайгуул	хайгуулын талбай	22 талбайд БХГ байгуулсан.	Шинээр 3 талбайд БХГ байгуулсан байна.	Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна.	Үндэсний статистикийн хороо, АМГТГ-ын статистик мэдээлэл	УУХҮЯ, АМГТГ
		Газрын тосны олборлолт	сая баррель	7.7	10.3	11.7	Үндэсний статистикийн хороо, АМГТГ-ын статистик мэдээлэл	УУХҮЯ, АМГТГ
2	2.4.2. Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	сая.тн	ТЭЗҮ боловсруулж байна.	ГТБҮйлдвэр ашиглалтанд орсон байна.	Дотоодын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээний 50% (1.2 сая.тн)-иас доошгүй хангасан байна.	УУХҮЯ, АМГТГ, Монгол газрын тос ТӨҮГ	УУХҮЯ, АМГТГ, “Монгол газрын тос” ТӨҮГ

3	2.4.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	ГТБ тоо хэмжээ	сая.тн	1.5	1.9	2.4	АМГТГ, ГЕГ	УУХҮЯ, АМГТГ, Газрын тосны үйлдвэр, Монголын нефть, хийн үндэсний ассоциаци, Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын холбоо, Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч, худалдаа эрхлэгч компаниуд
		Чанар, экологийн ангилал, к5	хувиар	7.7	50	80		
4	2.4.4. Газрын тосны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, ажлын байрыг нэмэгдүүлэх	Салбарын мэргэжилтэй боловсон хүчин	хүний тоо	10000	15000	20000	Үндэсний статистикийн хороо	УУХҮЯ, АМГТГ, Газрын тосны үйлдвэр, Монголын нефть, хийн үндэсний ассоциаци, Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын холбоо, Газрын тосны бүтээгдэхүүн
		Ажлын байр	орон тоо	6000	9000	12000		

								импортлогч, худалдаа эрхлэгч компаниуд, Гэрээлэгч компаниуд
5	2.4.5. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжил, бүс нутгийн хөгжлийг дэмжих	Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн зардал	сая.төг				УУХҮЯ, БОАЖЯ, Нутгийн удирдлагын байгууллагууд	УУХҮЯ, АМГТГ
		Дэвшилтэт техник технологи	сая.төг					
		Дэд бүтэц, бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт	сая.төг					
6	2.4.6. Газрын тосны салбарын мэдээлэл, судалгаа, шинжилгээний төв байгуулах	Олон улсын жишигт нийцсэн, мэдээлэл и тод, хүртээмжтэй мэдээлэл, судалгаа, шинжилгээний төв байгуулагдсан	судалгаа, шинжилгээ	Мэдээлэл, судалгаа, шинжилгээ ний төвийн төслийг хэлэлцэж байна.	- Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, газрын тосны бүтээгдэхүүн ий импорт, хангамжийн мэдээллийн	- Чулуун, тосны дээжинд шинжилгээ хийгддэг болсон байх, Нэгдсэн тайлан боловсруулж, эрдэм шинжилгээний ажил хийгдсэн байх,	АМГТГ-ын ЭБММТ, ГТУУТЛ	УУХҮЯ, АМГТГ

		байна.			иж бүрэн цахим сан үүсгэж, баяжуулсан байх, - Чичирхийллийн соронзон хальс /картридж/-ыг уншиж, анхан шатны боловсруулалт хийдэг болсон байх,	- Сэдэвчилсэн судалгааг хийсэн байх,		
7	2.4.7. Газрын тосны компани байгуулж, салбарыг хөгжүүлэх	Компани байгуулагдсан байна.		0			УУХҮЯ, АМГТГ	УУХҮЯ, АМГТГ

\*-хэрэгжүүлэх байгууллагуудыг хэрэгжилтийг хангах хариуцлагын эрэмбээр жагсаана.

**Тав. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр**

5.1. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлогдох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

5.2. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.2.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.2.2. хандивлагч орон болон олон улсын байгууллагын хандив, зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.2.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.2.4. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;

5.2.5 бусад эх үүсвэр.

**Зургаа. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутамд, хөндлөнгийн үнэлгээг дөрвөн жил тутамд хийж дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгана.